

ТӨВД ХЭМЭЭХ НЭРИЙН ШИНЖЛЭЛ

Жамбадондүв (БНХАУ)

Төвдийн түүх хийгээд нэр алин мэт нэгнийг шинжлэх хэрэгтэй бөгөөс эхлээд түүнд холбогдох үндсийг эрэн шинжилж уг сурвалжийг тодруулан эшийг батлахад бүтээгч товойлгон гаргасан сэлтээс шинжлэхэд асар их илт тул энд миний харьцууланы хэрээр “Төвд” (ᠲᠦᠪᠳᠦ) хэмээх нэрийг 6 зүйлийн үүднээс дурдах болой.

I. “Вод” (ᠲᠦᠪᠳᠦ; төвд) хэмээх нэр хэдийнээс гарсныг шинжлэх

Төгс найман гишүүнт Дунзан (ᠳᠦᠨᠵᠠᠨ) мөрний эцсээс эхлээд цаст уул нуруу, ариун газар нутагт арван буян бүрдсэн орон, дээд буяны үйлийг түгээх диваажингийн орон хэмээн алдаршсан Дод аарий-(ᠳᠣᠳᠠᠶᠠᠷᠢᠶᠢ-ᠲᠣᠳᠠᠶᠠᠷᠢᠶᠢ; баруун төвд)-н 3 аймаг, төв хэсэгт нь Үй зан-(ᠦᠶᠢᠵᠠᠨ)-гийн 4 аймаг, доод хэсэгт До (ᠳᠣ), Хам (ᠬᠠᠮ), Ган-(ᠭᠠᠨ)-ы 6-н орон үүнийг нийтэд нь “Вод” (ᠲᠦᠪᠳᠦ; төвд) хэмээн дуудах бөгөөд “...Тэр ч бидний энэ орныг асар эртнээс өөрийн хэлэнд “Вод жи юл” (ᠲᠦᠪᠳᠦᠵᠢᠶᠤᠯ; төвд орон) хэмээсэн...” гэсэн дотор эртнээс нэршсэн төдийгөөс өөр эшийн зүйл алинаар ч бүтээгдхүүн бүтээгч саадгүйгээр “Вод” (ᠲᠦᠪᠳᠦ; төвд) хэмээх нэр анхнаасаа буйг номлосонд сэжиг хэзээ ч үгүйн гол утга биш хэмээмүй. Бас Хүдон Зондуй Юндүн бээр зохиосон “Эх түүх” тэргүүтэнд эрт цагаас Ягчис тэргүүтэн хүмүүн бус 10 ванзад (ᠶᠠᠭᠴᠢᠰ) гарсны 8 үеийг номлосон буй бөгөөд тэр номлосон үе дотор “... 7-рт үл гэгээрсэн ах дүү 9-ийн эрхэнд үйлдээд орны нэрийг ч “Вод хам ня дүг (ᠲᠦᠪᠳᠦᠬᠠᠮᠨᠢᠶᠠᠳᠦᠭ; төвд орон 6 загас) хэмээв...” гэсэн түүнээс ч “Вод” (ᠲᠦᠪᠳᠦ; төвд) хэмээх нэр анх тэр цагаас буй нь илтээр үл барам төвдүүд өөрсдөө нэрлэсэн нэр мөн, тэгээд ч шалгадагт бүтсэн хэмээхүйд илт. Тэр цагаас эдүгээ хүртэл их хугацаа өнгөрсөн тул оюун ухааны хүчинд дулдуйдаж дахин үргэлжлүүлэн судалж үндэслэлийг гаргаж хэн бээр ч эс чадсан тул түүхэн илэрхий эх сурвалж үгүйг үзсэнээр хэн бээр ч баталж үл чадна.

Балар эртний нийгмийн үед мал сүрэг өсөх тутам өвс ногоо аажим багасч хүлээн суух аргагүй болсон тул өвс, ус бүрдсэн аль сайн орныг засаж амьдарч тэнд байгалийн гамшиг, зэрлэг араатны аюул зэргээс гэтлэхэд харилцан туслалцаанд шүтэж харилцах хэрэгтэй байснаар хэлний дохио найруулсан мэдлэгийн хэмжээнд орныг засаж “Га-еэ” (ᠭᠠᠡ) буюу “Ва еэ” (ᠪᠠᠡ) гэж дуудсан аялгуу дахин дахин дуудахын эрхээр “Вод” (ᠲᠦᠪᠳᠦ; төвд) гэж хэлэгдэх болсон юм хэмээнэ.

Өөр бусдын хувьд төвд орны газар нутгийн байдал нь ерөнхийдөө бусад газар оронтой адил бус, баруун, хойд хэсэг нь өндөрт; зүүн, өмнөд хэсэг нь нам доор газарт байдаг тул байгалийн нөлөөнд зохицон аж төрөх өндөр уулын газарт мал маллан амьдрагчийг “Врогба” (ᠠᠨᠢᠭᠦᠪᠠ; малчин), арай доор уур амьсгалын халуун хүйтэн тэнцэх тул тэнд газар тариалан голлон эрхлэгчийг “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээн дууддаг. Нам дор хүйтэн газар нутагт ойн аж ахуй голлон эрхлэгчийг “Ронва” (ᠷᠣᠨᠪᠠ) хэмээн дуудах амуй. Гэвч Бүжал (ᠪᠦᠵᠠᠯ) хааны уг язгуур Ярлүнд гарсанд таалснаар тэр үеийн газар тариалан голлон эрхэлдэг газар ганцхан Ярлүнг “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээн дуудах журам гарсан юм гэвээс бас ч биш ажээ. Ярлүнгийн ойр хавь тэргүүтнийг Сронзангамбо бээр Үй, Зан, Аарий лугаа сэлтэд эрхшээж газар орны хязгааруудад харьяат албатыг хурааж түүнээс хааны нэр, цолыг оронд барьж харьяат газар нутагт хамаарах орныг ямагт “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээсэн нэрийг барьсан юм хэмээх тэргүүтнийг тойм төдий шинжлэвээс “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээх нэр анхнаасаа буй юм, шалгадгаар бүтсэн нь илт.

II. “Вүд” (ᠪᠦᠳ; мултарах, зугтаах) хэмээхээс “Вод” (ᠪᠣᠳ; төвд) гэсэн үг гарсныг шинжлэх

Хөх дэвтэрт “... Номлогч, Чадагч ажирсан цагаас өмнө төгс тэмцлийн эхэнд Жавсангийн 5 хөвгүүн бээр 18 буюу 12 аймаг цэргийг дарсан үед Бади хэмээх хаан нэгэн аймаг цэрэг лүгээ сэлтэд байлдах үед эмэгтэй хүний дүрд хувилан зугтааж цастаны ууланд оршсон язгуураас эхэлж одоог хүртэл “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээн алдаршсаны тул болой...” гэдэг. Бас Улаан дэвтэрт “... Лхаса Гациг Га Холма-(ᠬᠣᠯᠮᠠ-ᠭᠠᠨᠬᠣᠯᠮᠠ) гаас гарсан Шагжийн язгуураас Шагжчэнбо, Шагжлижажи, Шагжридагба гурваас сүүлчийнх, хаан Жавсэн хэмээхийн бага хүү Бүнгигсог лүгээ сэлт эмэгтэй хүний дүрд хувилан цастаны зүгт зугтааж төвдийн хаан болсныг номлосон...” хэмээдэг. Дээрх хоёр эшээс ч “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээх нэр нь “Вүд”-(ᠪᠦᠳ; мултарах, зугтаах)-ийн учир шалтгаан аль нэгийг шүтэж дуу нь суларсан буюу бас бөгөөс хувирсан тэргүүтнийг үнэн хэмээн итгэн магад тодорхой өгүүлээгүйн дээр бичээчийн санаа бодолд хориг болсон буй.

Иймэрхүү адил төстэй эх сурвалж үнэхээр шалгадагт үзүүлэх учиргүй бөгөөс “Тотийн ном номлосон”-ы мөрийг дагасан нь лав, түүнээс илүү гарахгүй тул “Вүд”-(ᠪᠦᠳ; мултарах, зугтаах)-ээс “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээх нэр гарсан байдлыг эргэцүүлвээс “Вод” (ᠪᠣᠳ; төвд)

хэмээх дуу нь гарах асар ховор болно. “Вүд” (ᠪᠦᠳᠦ; мултарах, зугтаах) хэмээх орноос салж бусад оронд хүрснийг “Вүд” (ᠪᠦᠳᠦ; мултарах, зугтаах) буюу бас бөгөөс үг холбон найруулснаар “Вүд сон” (ᠪᠦᠳᠦ ᠰᠣᠨ; зугтаан явах) хэмээхийн утга нь хураангуйлваас орноос зугтаан явах хэмээх утгатай. Гэвч “Вод” (ᠪᠣᠳᠤ; төвд) хэмээхийн утга алин мөн хэмээвээс “Цагаан дэвтэр”-т “...Вод (ᠪᠣᠳᠤ; төвд) хэмээхийн утга нь юу ч номлоогүй, аяндаа бий болсон ...” гэсэн байдаг бөгөөд тайлбар юу ч өгүүлээгүй байна. Товчилбоос “Вүд” (ᠪᠦᠳᠦ; мултарах, зугтаах) хэмээх дууг хатуугаар уншваас ч “Вод” (ᠪᠣᠳᠤ; төвд) хэмээх дуу гарахгүйгээр үл барам өгүүлэгдхүүн өгүүлэгч алины хувиас ч их ялгааг үзсэн тул ихийг мэдэгч эрдэмтэн судлаач бүгдээр анхаарлаа холдуулалгүй бодит эх сурвалжийг шинжлэн судлах нь маш чухал хэрэг мөн.

III. “Вон” (ᠪᠣᠨ; бомбын шашин) хэмээснээс “Вод” (ᠪᠣᠳᠤ; төвд)
хэмээх нэр гарсныг шинжлэх

“Вон”-(ᠪᠣᠨ)-гоос “Вод” (ᠪᠣᠳᠤ; төвд) хэмээх нэр гарсан гэж үзвэл эхлээд “Вон” (ᠪᠣᠨ) хэмээхийн утга алин мөнийг тухайлан тодруулан мэдэх хэрэгтэй. Гэвч “Вон” (ᠪᠣᠨ) хэмээхийн утга аль буюу хэмээвээс “Чүнбо Годцан - (ᠴᠢᠨᠪᠣ ᠭᠣᠳᠴᠠᠨ)-гийн түүх” хэмээхэд “... “Вон” (ᠪᠣᠨ) гэдэг нь утгагүй хоосон биш юм ...” гэсэн нь олон мэргэдийн таалах ёс лугаа нийцэх болой. Түүгээр үл барам зарим нь “Са-вон” (ᠰᠠᠪᠣᠨ; үр хөрөнгө, вон-гийн орон) хэмээхийн уг сурвалж учир шалтгааныг ч үзүүлсэн байдаг.

“Сайтар номлосон их эрдэнийн сан” зохиолд “... Ерөнхийдөө “Вод хам” (ᠪᠣᠳᠤ ᠬᠠᠮ; төвд орон) хэмээх нь “Вон хам” (ᠪᠣᠨ ᠬᠠᠮ; Вон орон) хэмээсэн дуун сунжирч “Вод хам” (ᠪᠣᠳᠤ ᠬᠠᠮ; төвд орон) хэмээн эрт үеэс алдаршсан гэж үзвэл ... тэнд Юндэн-(ᠶᠦᠨᠳᠡᠨ)-гийн вон (ᠪᠣᠨ) гарсан эртний үед хаан гэж байхгүй байхад Вон (ᠪᠣᠨ) гарсан хийгээд хааны ёс цааз үгүй үед Вон-(ᠪᠣᠨ)-гийн ёс байсан утгаар Вон хам (ᠪᠣᠨ ᠬᠠᠮ; Вонгийн орон) хэмээн алдаршсан болой...” гэдэг. Энд “Вод” (ᠪᠣᠳᠤ; төвд) хэмээх нэр “Вон”-(ᠪᠣᠨ)-гоос гарсан гэх үндэслэл үнэн бодитойг баталсан буй. Гэвч “Вон” (ᠪᠣᠨ) хийгээд “Вод” (ᠪᠣᠳᠤ; төвд) хэмээх нэрийг уншваас дуу нь өчүүхэн төдий адил үзэгдэх авч утгыг нь нэгдүгээрт авч үзэх нь чухал болой. Төвдийн хаан Намрисронзанг энэ оронд Вонбо-(ᠪᠣᠨᠪᠣ)-ын шашныг ямагт дэлгэрүүлсэн тул хятадууд түүнийг “Пон юл” (ᠪᠣᠨᠵᠤᠯ) хэмээн дуудах авч “Вон юл” (ᠪᠣᠨᠵᠤᠯ; вонгийн орон) хэмээх нэр лүгээ учир шалтгаан ойр болой.

Ерөнхийдөө төвд үсгийн нэр олон бөгөөд дагавар үсэг да (ᠦ),

на (ᠶ) хоёр харилцан солигдох учир шалтгаан буй нь эртний нэрийн нэгэн журам мөн, эсэхүл харгалзах газар хамааруулж тавихын эрхээр солих журам буй тэргүүтэн шалтгаан тодорхой бус бөгөөд чүнбо ба чүдбо (ᠰᠢᠨᠪᠣᠪᠣᠨ; багтаах-оруулах), занбо ба задбо (ᠨᠠᠵᠢᠨᠪᠣᠪᠣᠨ; хаан-сайд) зэрэг бичсэн жишээ олныг үзэх тул түүнээс “Вон” (ᠪᠣᠨ) хийгээд “Вод” (ᠪᠣᠳ) хоёрын дагавар бас харилцан солигдож болохын магадлал юуг ч үзүүлэх учиргүй.

Энэтхэг хийгээд хятадаас төвдөл бурхны шашин дэлгэрээгүй үед төвдөл байсан шашны ерөнхий нэрийг “Вон” (ᠪᠣᠨ) гэсэн бөгөөд энэ шашны багш нарыг “Вон шэн” (ᠪᠣᠨᠰᠡᠨ), энэ шашныг шүтэгчдийг “Вонбо” (ᠪᠣᠨᠪᠣ) гэх нэр гарсан буй. “Вонбо”-(ᠪᠣᠨᠪᠣ)-д ч дотор зуур адил бус зүйл олон гарсан бөгөөд “Жүй вонбо (ᠵᠢᠢᠪᠣᠨᠪᠣ; шалтгааны вонбо) 4 зүйл, Вон-(ᠪᠣᠨ)-гийн мэдэлтэн 12” тэргүүтэн бас улай тахигчийн вонбо (ᠪᠣᠨᠪᠣ), дүд вон (ᠳᠦᠳᠪᠣᠨ; чөтгөрийн вон), зан вон (ᠵᠠᠨᠪᠣᠨ; албины вон) хэмээх вонбо (ᠪᠣᠨᠪᠣ) гарсан нь тодорхой тул “Вон” (ᠪᠣᠨ) хэмээх энэ нэр нь ерөнхий нэр мөнөөр үл барам “Вод” (ᠪᠣᠳ) хэмээх нэр нь “Вон”-(ᠪᠣᠨ)-гоос гарсан гэвэл утга урьд хойно харшлахгүй тул үнэн зөв хэмээн бүгдээр үзэхэд хориггүй тодорхой юм.

Ү. Хааны нэр, цолноос төвд хэмээх нэр гарсныг шинжлэх

Тан улсын хаан Мүүзүн хийгээд төвдийн хаан Тиралбажан хоёр нийтийн он тооллын 823 онд байгуулсан Лхасын хөшөөний зүүн талын бичгийн 5-р мөрөнд “... Хувилгаан тэнгэр хаан Одэ Бүжал ...” (ᠬᠤᠪᠢᠯᠭᠠᠨᠲᠡᠨᠭᠡᠷᠬᠠᠨᠣᠳᠡᠪᠦᠵᠠᠯᠠᠭᠠᠨ) гэж бичсэн нь одоо ч тодорхой уншигддаг. Түүнээс “Бүр-жал” (ᠪᠦᠷᠵᠠᠯ)¹ буюу “Бүр-жал” (ᠪᠦᠷᠵᠠᠯ)² бас “Бү-жал” (ᠪᠦᠵᠠᠯ)³ тэргүүтэн нэр бодит бус бөгөөд “Бү-жал” (ᠪᠦᠵᠠᠯ) нь үнэнд бүтсэн буйгаас “Бү” (ᠪᠦ; үс) хэмээхийг барих ёсыг ч ээлжлэн таалах журам адил бусын дууг номлосон буй.

Төвдийн анхны хаан Наатизанбо-(Хүзүүн сандалт)-гоос тоолон 7 үе тэд огторгуйн 7 сандалт хэмээн алдаршсан бөгөөд тэд нар чандар үгүй огторгуйд солонго мэт замхарсан тул нэрийг “Бүр жал” (ᠪᠦᠷᠵᠠᠯ; чандар хаан) хэмээхийг барьсан юм хэмээнэ. Зарим нэгэн бээр Жатизанбо (Шувуун сандалт) хаан “Бү-вой жалбо” (ᠪᠦᠵᠠᠯᠪᠣ; үсний хаан) гэж соёрхсон нь үсний завсраас төрж төвдийн хаан болон залагдсанд дулдуйдаж нэрийг “Бү-жал” (ᠪᠦᠵᠠᠯ; үсэн хаан) хэмээсэн хийгээд Одэ Бүжал (ᠣᠳᠡᠪᠦᠵᠠᠯ) хэмээсэн эртний нэрийн дуун сунжирч Вод-дэ (ᠪᠣᠳ-дэ), Во-дэ (ᠪᠣ-дэ); Бү-дэ Гонжал (ᠪᠦᠵᠠᠯ) хэмээсэн үг урьд хойно хоёроос Бү-жал (ᠪᠦᠵᠠᠯ) хэмээн бүтсэн гэж өгүүлэх журам буй

боловч утгыг тэр мэт мөн бишийн үүднээс дахин шинжлэн судлах хэрэгтэй байна.

Хааны нэрийг оронд барих нь үлгэрлэвээс Жин-(ᠵᠢᠨ)-гийн угсаатан барьсан Хятадын бүх нутгийг Жинжа (ᠵᠢᠨᠵᠢ) хийгээд хаан Вхрада (ᠪᠬᠢᠷᠳᠠ) бээр барьсан Жагарын бүх орныг Вхрада (ᠪᠬᠢᠷᠳᠠ) хэмээн дууддаг байсан бөгөөд түүнтэй адил үүднээс алинд алиныг зохистойгоор үзүүлж болохын шалтгаан лүгээ холбосон байж магад. Бас зарим нь “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээх энэ нэр нь Домад⁴ (ᠳᠣᠮᠠᠳ)-ын орны хэлэнд авиаг өчүүхэн төдий хатуугаар уншсанаар “Од” (ᠣᠳ; гэрэл) хэмээх дуун өөрийн хүчинд гарах бөгөөд олон нутагт эртнээс “Од юл” (ᠣᠳᠢᠮᠤ; гэрэлт орон) гэж дуудах журам гарсныг номлодог. Хаан Наатизанбо (Хүзүүн сандалт) нь гэрэлт тэнгэрийн язгуур гаралтай гэж алдаршсан бөгөөд хааны нэрийг Од дэ Бүржал (ᠣᠳᠡᠪᠦᠷᠵᠠᠯ) хэмээн дуулсаныг оронд барьж алдаршуулсан гэж үзэх ёс бас зарим нэг буй.

Ү. “Вод” (ᠪᠣᠳ; төвд) гэж Энэтхэгчүүд нэрлэсэн үгүйг шинжлэх

Энд бас усны эх цас хийгээд номын уг Жагарт хүрсэн үлгэр мэт “Вод” (ᠪᠣᠳ; төвд) гэж Энэтхэгчүүд нэрлэсэн хэмээн үзэх нь шинжлэн судлах нэгэн хэрэг болой. Хайван Намхай Норов (Мэргэн эрхт Огторгуйн эрдэнэ) бээр “Бү-жал” (ᠪᠦᠵᠠᠯ; үсэн хаан) хэмээх энэ эртний хааны уг сурвалж бодитойгоос уламжилж “Вод” (ᠪᠣᠳ; төвд)-ын нэрийг тодорхойлсон хэмээн үзсэн ч буй. Энэ нэрийг Энэтхэгчүүд өгсөн гэж ярих бөгөөс бас үндэслэл муутай бөгөөд О-дэ-Бү-жал (ᠣᠳᠡᠪᠦᠵᠠᠯ;)-д хүрэх хийгээд О-дэ-Бү-жал (ᠣᠳᠡᠪᠦᠵᠠᠯ;)-н жинхэнэ төвд хүн мөн тул энэтхэгчүүд төвдийн хаан болгон илгээгээгүйг хэн ч эргэцүүлэн өгүүлж чадна. Юуны тулд хэмээвээс Хлока тойргийн Чьонгтэ хошуунд байдаг Тидэсронзан хааны булшны өмнө байгуулсан чулуун хөшөөний бичгийн нэг хоёрдугаар мөрөнд “... Тэнгэрийн хүү Оддэ Бүжал (ᠣᠳᠡᠪᠦᠵᠠᠯ;)-аа хаан огторгуй тэнгэрээс хүний хаан болон ирсэн...”, Лхасын Зүглагхан (ᠵᠢᠭᠯᠠᠭᠬᠠᠨ; их хийд) хийдийн урд талд байгуулсан “Вон шан Вүнүн (ᠪᠣᠨᠰᠠᠨᠪᠦᠨᠦᠨ;)-гийн хөшөө” хэмээхийн зүүн талын бичгийн 5-9-р мөрөнд “...Хувилгаан тэнгэр Одэ Бүжал (ᠣᠳᠡᠪᠦᠵᠠᠯ;)-аа хаан нутаг орноо солин Үн (ᠦᠨ)-ээс хүний хаан, төвдийн их хаан болж цаст өндөр уулын нь дунд, их мөрний нь эхэнд өндөрлөг ариун газарт огторгуй тэнгэрээс хүний хаан болон ирсэн бөгөөд их дээдийн номоор нь тэнгэрийн төрийг байгуулсан ...” гэх зэрэг бичигт тодорхой байдаг. Тэдгээрт ч “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээн энэтхэгчүүд нэрлэсэн гэх эх сурвалж үгүйг номлосноор үл барам Одэ Бүжал (ᠣᠳᠡᠪᠦᠵᠠᠯ;)-аа хаан ч энэтхэг хүн

бус, огторгуй тэнгэрээс хүний хаан болон ирсэн түүхийг тодорхой дурдсан буй тул болой. Харин “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээн энэтхэгчүүд нэрлэсэн, Одэ Бүжал (ᠣᠳᠡᠪᠦᠵᠠᠯ) хаан ч энэтхэг мөн хэмээвээс хааны үеийн хөшөө болон хадны бичээс бүгдэд Наатизанбо (Хүзүүн сандалт) хаан энэтхэгээс ирсэн хийгээд Шагжийн язгуур гаралтай гэж өгүүлээгүй, түүнтэй холбоотой ёгт санаа илэрхийлснийг үзээгүй бөгөөд шашны үнэт зүйл болох “Вүнүн цудба” (ᠪᠦᠨᠦᠨᠴᠢᠳᠪᠠ) тангарагт орох)-гийн хөшөөний бичигт хааны угсаа гарал, жагарын номын хааны түүх тэдгээрийг үл өгүүлэн орхисон хийгээд “Вон” (ᠪᠣᠨ)-гийн шашны номлол ёсоор “... Огторгуй тэнгэрээс бууж хүний хаан болсон...” хэмээсэн бүдэг бадаг үндэслэлийг тухайлан үргэлжлүүлэн судлах хэрэгтэй байна. Энэ үндэслэл нь чулууны хэлтэрхийг эвлүүлэх хийгээд сарлагийн хамрыг нүшгэн гараараа цохихын үлгэр мэт бөгөөд өөртөө итгэн цөхрөлтгүй оролдон бодит үнэний хүчийг ухаарсан тул тэр мэт харьцуулбаас бас үндсийг тодруулан гаргахад хэцүү хэмээн санана.

Иймийн тул тулгуур үндэслэлийг батлах бөгөөд бүтээгдхүүн бүтээгч алины нь ч хувиас эшийн зүйлийн үрийг сайтар боловсруулж шинжлэх үндсийг сайтар мэдэх нь туйлын чухал хийгээд би бээр “Вод” (ᠪᠣᠳ; төвд) гэж энэтхэгчүүд нэрлээгүй, харин “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээх нэр нь төвд хэлнээс энэтхэгт түгсэн хэмээн үзэж байна.

ҮІ. “Төвд” (ᠲᠦᠪᠳ) хэмээн бичих тусгай журам гарсныг шинжлэх

Дээр дурдсан “Вүд” (ᠪᠦᠳ), “Вон” (ᠪᠣᠨ), “Хааны нэр, цол” гурвын нэрнээс “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээх нэр гарсныг өчүүхэн төдий өгүүлсэн. Түүнээс уншиж найруулах байдлын үүднээс адил бус дүрс ямар ч төрөлд хувирч магадгүй. Үлгэрлэвээс “Вод” (ᠪᠣᠳ; төвд) гэхийг Амдогийн аман ярианд “Бод” (ᠪᠣᠳ), Лхасын аман ярианд “Вод” (ᠪᠣᠳ; төвд) гэж дууддаг бөгөөд ямарч байсан “Вод” (ᠪᠣᠳ; төвд) гэсэн утга тодорхой ч унших дуудлага адил бусын эрхээр өөрийн чанарын агуулсан нэр гарч чадахгүй, өгүүлэхэд асар бэрх болой.

Энэтхэгчүүд биднийг “Вхо-да” (ᠪᠬᠣᠰᠠ) хэмээн дууддаг бөгөөд эрт цагийн унших ёсоор “Вод” (ᠪᠣᠳ; төвд) гэж дуудсан үе, өнөө үе хоёрын дуу тодорхой гарсны эрхээр “Вод” (ᠪᠣᠳ; төвд), “Вход” (ᠪᠬᠣᠳ), “Входа” (ᠪᠬᠣᠳᠠ) гэх зэргээр хувирсан ч “Вод” (ᠪᠣᠳ; төвд) хэмээх утгатай үг нь өөр бусдын хэлэнд сунжирсан буй за.

Энэтхэгчүүд анх “Вод” (ᠪᠣᠳ; төвд) гэж нэрлээгүй хэмээн номлосон “Цагаан дэвтэр”-т олон янзын санаа байх болой. Тухайлбал: “Дод-

вод” (ལོ་ལོ་ལོ་; дээд төвд), “Дод-ба” (ལོ་ལོ་ལོ་; дээд) гэх зэрэг нэр сунжирч “Тү-во” (ལོ་ལོ་) гэж Тан улсын үед дуудагдсан. Бас зарим нь “Лхо-вод” (ལོ་ལོ་; өмнөд төвд), “То-вод” (ལོ་ལོ་; төвдийн өндөрлөг) хийгээд “Вон” (ལོ་) гэх зэрэг нэрийн дуудлага сунжирч дуудагдсан нь илэрхий байна гэх мэт санал олон байдаг.

Дээр өгүүлсэн “...Төвдийн хаан Одэ Бүржал (ལོ་ལོ་ལོ་) нь огторгуй тэнгэрээс хүний хаан болон ирсэн...” гэх эшлэл “О-дэ (дэ)” (ལོ་) гэж тодорхой байдаг. Түүний ялгаа их бус тул тодорхой баримтыг дурдсан юм. Утгыг “Одэ” (ལོ་), “Одэ” (ལོ་) гэх энэ хоёрт ч их ялгаа үгүй мэт. “Одэ” (ལོ་) ба “Во-дэ” (ལོ་) эсвэл “Вод-дэ” (ལོ་) гэхэд ч их ялгаа үгүй бөгөөд эдгээр үгсийн утгыг “Вод” (ལོ་; төвд) хэмээх нэгэн үндсэнд үзэж ойлгож болно.

Санскрит хэлэнд төвдийг “Вхо-да” (ལོ་) гэх нь “Вод” (ལོ་; төвд) хэмээхийг санскрит хэлний ёсоор бичсэн бөгөөд нэрийн шүтээн “ва” (ལ), дагавар “да” (ལ) үсэг хоёрын авиа өчүүхэн төдий хүчтэй гарсны эрхээр “Вхо-да” (ལོ་) хэмээх энэ нэр бүтсэн болой. Санскрит хэлээр “Вхо-да” (ལོ་) гэж дуудсан учраас “Вод” (bod; төвд) гэж бичих журам гараагүй гэдгийг хэн ч ойлгож чадна.

Нэг үгээр хэлбэл дээр өгүүлсэн бүгдээс “Вод” (ལོ་; төвд) гэх нэрийн дуудлага гарч үл хувирах нэгэн нэр болсон болой. Түүнчлэн бичих журам ч тэр мэт тоймгүй олон гарсан тул өөр бусад адил бус зүйлийн нэр нь “Вод” (ལོ་; төвд) гэсэн нэр болон сунжраагүй хэмээн үзэж байна.

Төвд хэлнээс орчуулсан Ш.Догмийчойдон

།།ལོ་ལོ་ལོ་།། “Хятадын төвд орон” сэтгүүл, 1999, №3(36)